

8

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ИНТЕГРАЦИД
МОНГОЛ УЛС ОРОЛЦОХ НЬ

Д.Бямбаа, С.Отгонбаатар

Өнөөдөр дэлхийн өнцөг булан бүрт улс орнууд эдийн засгийн хамтын сонирголоо нэгтгэн, газар зүйн ойр дөт байдлыг харгалзан бие биендээ хөнгөлттэй нөхцөл олгох зэргээр нэгдэн нийлж байгаа бүс нутгийн хандлага нь тухайн бүс нутагт хамрагдаж байгаа тэдгээр орнуудын хөгжлийн ирээдүйг улам бүр тодорхойлох болж байна. Ийм хандлагууд бүр 1993 онд Европын нийгэмлэг нийтийн зах зээл бий болгож, Хойт Америкт АНУ, Канад чөлөөт бүс байгуулсанаар эхэлсэн нь өнөөдөр Ази тивд ч өрнөж байна.

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага Ази тив рүү шилжин XXI зуун нь Азийн зуун болно гэж олонхи улс төрч, эдийн засагчид тодорхойлж байгаа билээ. Нэн ялангуяа Монгол улс багтаж байгаа Зүүн хойд Азийн бүс нутаг энэхүү дүгнэлтийг батлан хэрэгжүүлэхэд "зүтгүүрийн" үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж болно.

Зүүн Хойд Азийн салбар бүсэд: **БНХАУ-ын зүүн хойд хэсэг, ОХУ-ын алс дорнод, Монгол улсын дорнод хэсэг, БНАСАУ, БНСУ, Япон улс** багтаж байдаг. Энэ нь Азийн нийт хүн амын 10% буюу 350 сая хүнтэй, өндөр технологжсон эдийн засаг болон шилжилтийн үеийн эдийн засагт байгаа газар нутаг юм. Бүс нутгийн чадварлаг тэгсэн мөртлөө хямд ажиллах хүчин, үйлдвэрлэл, байгалийн баялаг зэрэгт нь илүү их худалдаа, хөрөнгө оруулалт хийх боломжтой.

Зүүн Хойд Азийн эдийн засгийн хүрээ, хамтын ажиллагааны тухай арав гаруй жилийн өмнөөс яригдаж эхэлсэн ч хөгжил нь удаашралтай байна. Гэхдээ энэ бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа интеграцын үйл явц нь Америк, Европын холбооны улсуудын дунд явагдаж байгаа үйл явцаас нилээд өвөрмөц юм. Учир нь энэ салбар дэд бүсийн орнууд улс төрийн тогтолцооны хувьд ялгаатай, хөгжлийн хувьд харилцан адилгүй, шашин шүтлэг, эдийн засгийн үндсэн нөхцөл нь өөр өөр зэрэг нь интеграцын үйл явцын өрнөлтөд нөлөөлж байгаа юм. Эдгээр талуудыг бодолцон үзвэл өнгөрсөн 10 жилийн хугацаанд олсон эдийн засгийн хөгжлийн ололт нь томоохон амжилт гэж үзэж болохоор байна. Энэ бүс нутагт хамгийн эрчимтэй хөгжиж буй орон нь БНХАУ юм. Хятад улсад эдийн засгийн өсөлт болон өмч хувьчлал амжилттай явагдаж байна. Статистикийн үүднээс үзвэл ОХУ, БНАСАУ-д эдийн засгийн өсөлт ерөнхийдөө зогсонги, нийгмийн нийт бүтээгдэхүүний хэмжээ нилээд буурсан байгаа ч бүс нутгийн эдийн засгийн интеграцийн хүрээнд тодорхой ажлууд хийгдэж байгаа юм. БНАСАУ-д Рашин, Сэнпо бүс нутагт 1996 оны IX сар, 1998 оны IX сард олон улсын хөрөнгө оруулалтын хурал болж,

Хунчун хүрэх шинэ зам тавигдаж, 1000 хүн байрлах зочид буудал баригдаж байна. Орон нутгийн мөнгөн тэмдэгт гадаадын валюттай чөлөөтэй хөрвөдөг болсон зэргийг дурьдаж болно. Зүүн Хойд Азийн хувьд ирэх 10-20 жилд хөгжлийн хурд нилээд өндөр байх төлөвтэй байна. Өнөөг хүртэл хөгжил нь голдуу нэг улсын хүрээнд яригдаж байлаа. Харин цаашид Зүүн Хойд Азийн орнуудын хооронд харилцаа хамтын ажиллагаа ихээхэн идэвхжиж, үүний үр дүнд улс орон тус бүр олон улсын хөдөлмөрийн хуваарийн үр шимийг улам бүр ихээр хүртэх боломжтой болж байна. Энэ нааштай эхлэлийг урт удаан хугацааны үр дүнтэй ажил болгоход тус бүс нутгийн орнууд хамтран шийдвэрлэх олон асуудлууд тулгарч байна. Тухайлбал:

- Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох;
- Энэхүү бүс нутгийн хамтын ажиллагаанд орон бүрийн оролцох сонирхол, боломжийг тодорхойлох;
- Бүс нутгийн орнууд судалгаа шинжилгээний чиглэлээр нягт хамтран ажиллаж үр нөлөө бүхий механизмыг бий болгох асуудлуудыг нэрлэж болно.

Зүүн Хойд Азийн орнууд газар зүйн хувьд хөршилсөн, харилцан хамаарал ихтэй, стратегийн чухал ач холбогдолтой нутаг юм. Өөрөөр хэлбэл, тус бүс нутгийн орон бүр харилцан нэг нэгийгээ сэлбэн нөхөх өөрийн гэсэн давуулаг онцлогтой. Энэхүү харилцан шүтэлцээ, давуулаг онцлогуудыг хамтын ажиллагаагаар зохицуулан хөгжүүлэх өргөн боломжтой нь харагдаж байна.

Эдгээр орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны онцлог нь харилцан бие биенээ нөхөх буюу босоо тэнхлэгийн хөдөлмөрийн хуваарьт зохицож байгаа юм. Үүнд:

- | | |
|-----------------------|--|
| Япон, Солонгос | - Хөрөнгийн чадавхи, дэлхийд тэргүүлэх шинэ технологитой |
| ОХУ | - Байгалийн арвин нөөцтэй |
| БНХАУ | - ХАА-н болон хөдөлмөрийн арвин нөөцтэй |
| БНСАУ | - Хөдөлмөрийн болон байгалийн нөөцтэй |
| Монгол | - Байгалийн чамгүй нөөцтэй эдгээр болно. |

Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны хэлбэрүүд, түүний онцлогийг дараах паар авч үзэж болох юм. Үүнд:

- Хоёр талын хамтын ажиллагаа (засгийн газар хоорондын)
- Хэсэг бүлэг орнуудын хоорондын хамтын ажиллагаа
- Хөгжингүй их гүрнүүд ба жижиг буурай орнуудын хамтын ажиллагаа
- АНУ болон Европын гүрнүүд ба АНД орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааг нэрлэж болох юм.

Одоо тус бүс нутгийн эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүдийг авч үзье.

ДНБ болон нэг хүнд ногдох орлогын үзүүлэлт

Хүснэгт №1

1998	ДНБ (тэрбум ам.доллар)	Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)	Хүн ам (сая)
Хятад	1.085	868	1.125.0
БНАСАУ	11	491	22.4
Япон	3.798	30.047	126.4
Монгол	1	417	2.4
Өмнөд Солонгос	321	6.918	46.4
Орос	277	1.891	146.5

ЗХА-ийн худалдааны урсгал -1998
(сая ам. доллар)

		Экспорт	Импорт
Хятад*	БНАСАУ	624	134
	Япон	38,840	51,558
	Монгол	63	95
	Өмнөд Солонгос	8,048	23,929
	Орос	2,276	4,402
	Дүн	49,851	80,118
БНАСАУ*	Хятад	134	624
	Япон	269	197
	Монгол	0	0
	Өмнөд Солонгос	-	-
	Орос	15	81
	Дүн	418	902
Япон	Хятад	42,979	39,271
	БНАСАУ	197	269
	Монгол	55	12
	Өмнөд Солонгос	16,713	12,642
	Орос	972	2,893
	Дүн	60,916	55,087
Өмнөд Солонгос	Хятад	21,753	8,853
	БНАСАУ	-	-
	Япон	11,654	18,360
	Монгол	36	31
	Орос	909	564
	Дүн	34,352	27,808
ОХУ	Хятад	3,254	1,150
	БНАСАУ	81	15
	Япон	2,170	801
	Монгол	145	46
	Өмнөд Солонгос	513	1,000
	Дүн	6,163	3,012
Монгол*	Хятад	95	63
	БНАСАУ	0	0
	Япон	12	55
	Өмнөд Солонгос	31	36
	Орос	46	145
	Дүн	184	299

1998 оны худалдааны эргэлт /экспорт, импорт/

Хүснэгт №2

Бараа үйлчилгээний экспорт

1998	Нийт экспорт (сая.ам.доллар)	Экспортын ДНБ-д эзлэх хувь	Нийт экспортод ЗХА- ын экспортын эзлэх хувь
Монгол	317	20	58
БНАСАУ	909	8	46
Өмнөд Солонгос	126.058	39	27
Хятад*	258.814	24	19
Япон	392.339	10	16
Орос	69.730	25	9

Бараа үйлчилгээний импорт

1998	Нийт импорт (сая ам.доллар)	Импортын ДНБ-д эзлэх хувь	Нийт импортод ЗХА-ын импортын эзлэх хувь
Монгол	472	32	63
БНАСАУ	1.687	15	53
Өмнөд Солонгос	243.346	22	33
Хятад*	103.256	32	27
Япон	283.124	7	19
Орос	42.476	15	7

Зүүн Хойд Азийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн түвшинд хоёр талын харилцаа зонхилж байна. Гэхдээ бүс нутгийн хүрээнд зам харилцааны нэгдсэн сүлжээ байгуулах, худалдааг дэмжих зорилгоор нээлттэй бүс байгуулах, хамтарсан үйлдвэр байгуулах, эрчим хүч, нефть, хийн шугам байгуулах, аялал жуулчлал хөгжүүлэх гэх мэт олон улсын томоохон төслийг хэрэгжүүлэх алхамууд нь олон талын хамтын ажиллагааны эхлэл болж байна. Эдгээрийн дотроос томоохон нь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй "Түмэн голыг хөгжүүлэх" төсөл юм. Энэхүү төсөл нь Түмэн голын гурвалжинд 20 жилийн хугацаанд 30 тэрбум ам. долларын хөрөнгөөр 10000 кв.км нутагт олон улсын эдийн засаг-техникийн цоо шинэ нээлттэй район байгуулж ЗХА-ийн бүс нутгийн үйлдвэр худалдаа, тээвэр холбоо санхүүгийн төв болгохоор төлөвлөсөн. Энэ төслийг хэрэгжүүлэхэд юуны өмнө 500 мянган хүн ам суурьших ЗХА-ийн нэгэн томоохон үйлдвэрлэл, эргэлтийн суурь бааз бүхий хот байгуулах явдал юм.

Монгол Улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Ази Номхон Далайн бүс нутаг түүний дотор Зүүн Хойд Азийн хамтын ажиллагаа аюулгүй байдлын асуудлаар хоёр болон олон талын хэмжээнд санал бодлоо солилцох, олон талт яриа хэлэлцээнд Монгол улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс идэвхтэй оролцоно гэж заасан. Зүүн Хойд Азийн хамтын ажиллагаанд оролцох нь Монгол Улсын хувьд улс төр эдийн засгийн чухал ач холбогдолтой асуудал юм. Эдүгээ Монгол Улс тус бүс нутгийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх интеграцийн хөгжлийг гүнзгийрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Монгол улсын гадаад худалдааны 60 орчим хувь нь Ази Номхон Далайн орнууд, түүний дотор

Зүүн Хойд Азийн бүс нутагт оногдож байгаа нь манай улсын эдийн засаг энэ бүс нутгийн салшгүй нэг хэсэг мөн болохыг харуулж байна.

Монгол Улсаас 1998 онд Зүүн Хойд Азийн орнуудтай хийсэн худалдааны үзүүлэлтийг авч үзвэл:

		Экспорт	Импорт
		(сая ам.доллар)	
Монгол*	Хятад	95	63
	БНАСАУ	0	0
	Япон	12	55
	Өмнөд Солонгос	31	36
	Орос	46	145
	Дүн	184	299

Тухайн онд Монгол улсын гадаад худалдааны нийт дүн 789.0 сая ам. доллар байснаас экспорт 316.8, импорт 472.4 сая ам. доллар хүрч байна.

Өнөө үед Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа нь:

- Шууд хөрөнгө оруулалт
- Гадаадын зээл тусламж
- Гадаад худалдаа гэсэн гурван үндсэн чиглэлээр хэрэгжиж байна.

Монгол улс болон Зүүн Хойд Азийн орнуудын хоёр ба олон талын хамтын ажиллагаа хэрхэн хөгжиж байгааг авч үзье.

Монгол-Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагаа. Солонгос-Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа 1990 оны 3-р сард хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноор эхэлсэн билээ. 1991 онд Худалдаа хөрөнгө оруулалтын баталгааны гэрээ, 1992 онд Гаалийн давхар татвараас чөлөөлөх гэрээ байгуулсан нь хоёр орны худалдааг нэмэгдүүлэхэд ихээхэн тус дэм болжээ. Одоо Солонгос улс Орос, Хятад, Швейцар, Японы дараа орох Монголын худалдааны тав дахь том түнш болжээ. Солонгос улс бөс бараа, суудлын машин, болон хуванцар бүтээгдэхүүн зэргийг голлон Монголд нийлүүлж байгаа бөгөөд харин Монгол эмийн түүхий эд, ноос, модон эдлэл, савхи зэргийг Солонгост нийлүүлж байна.

Солонгос улсаас Монгол улстай хийсэн худалдаа
(мянган ам. доллараар) (%)

Хүснэгт №3

Үзүүлэлт	1994	1995	1996	1997	1998
Худалдааны нийт дүн	23.544 (213.4)	37.650 (59.5)	28.081 (-25.4)	28.095 (0.05)	44.375 (579)
Экспорт	18.700 (429.3)	27.957 (49.5)	26.017 (-6.9)	25.661 (-1.4)	39.195 (52.7)
Импорт	4.844 (21.7)	9.693 (100.1)	2.064 (-78.7)	2.434 (17.9)	5.180 (112.8)
Тэнцэл	13.856	18.264	23.953	23.227	34.015

Монгол улсын хувьд хөрөнгө оруулалтын орчин ядуу, дотоодын зах зээл жижиг, мэргэжлийн ажилчид дутагдалтай, хоёр талын ашиг бага, хүн ам цөөн, мэдээлэл хомс, тээвэрлэлт хүндрэлтэй зэргээс шалтгаалж Солонгосын шууд хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа юм.

Хэдийгээр байдал ийм байгаа гэсэн ч Солонгосын шууд хөрөнгө оруулалт 1997 онд 8.9 сая ам доллар болж 1998 онд өсөлт нь 52 хувь болов. Энэ нь оёдлын үйлдвэр, худалдаа, ресторан, тээвэр, мебелийн үйлдвэрлэл, авто машины засвар болон ахуйн хими цэвэрлэгээ гэх мэт олон төрлийн салбарт хөрөнгө оруулсантай холбоотой юм. Солонгос улс одоо Хятад, Япон, Оросын дараа орох Монголын дөрөв дэх том хөрөнгө оруулагч түнш болоод байна. Монголын Гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэлийн Товчоонд Солонгос улсын дагнасан болон хамтарсан 103 аж ахуйн нэгж бүртгэгдээд байна. Мөн Самсунг, Хьюндай, Самван корпорацийн салбар контор Монголд нээгдэв. Улаанбаатар хотын эрүүл мэндийн төвтэй хамтарсан Йон сей (Найрамдал) эмнэлэг 1997 онд Монголын Худалдаа Үйлдвэрийн Танхимаас гадаадын хөрөнгө оруулалт бүхий шилдэг байгууллагаар шалгарчээ.

Солонгос-Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв. Хэдийгээр Монгол улс зэс молибден, нүүрс, нефть зэрэг байгалийн арвин их баялагтай ч түүний 2.3 сая хүн ам бүхий жижиг зах зээл, газар зүйн байршил зэрэг хүчин зүйл нь хөрөнгө оруулалтад хязгаар тогтооход хүргэдэг. Иймд өргөн хэрэглээний бараа хангамж болон зочид буудал, ресторан, аялал жуулчлалын агентлаг, жуулчдын тээвэр гэх мэт үйлчилгээний салбарт бага хэмжээний төсөлд хөрөнгө оруулах нь илүү тохиромжтой юм. Монголд тээврийн хэрэгсэл нэмэгдсээр байхад шатахуун түгээгүүр, машин засвар зэрэг үйлчилгээний салбарын хөгжилт хоцрогдонгүй байгааг харгалзвал энэ салбарт хөрөнгө оруулах нь ихээхэн ирээдүйтэй юм. Түүнээс гадна хотууд тэлж, уламжлалт нүүдлийн хэв маяг улам улам өөрчлөгдөн суурин амьдралд шилжин буйтай уялдан амьдралын орчинтой холбогдох бизнес ч ирээдүйтэй болж байна.

Түүхий эд боловсруулах технологи хөгжөөгүйгээс Монгол улс ноос, зэс, молибден, алтаа эцсийн бүтээгдэхүүн болгохгүй түүхий эд хэлбэрээр гадаадад их хэмжээгээр гаргадаг учир энэ салбарт хөрөнгө оруулах нь ашигтай. Монголын засгийн газар байгалийн баялаг ашиглах төсөлд бусад орны компаниудтай хамтарч ажиллахаар гарын үсэг нэгэнт зурсан. Гэхдээ энэ талын үйл ажиллагаа их хэмжээний зардал шаардагдах хийгээд өндөр эрсдэлтэйг харгалзан төслийг Солонгосын болон бусад орны бизнес эрхлэгчидтэй хамтарч гүйцэтгэх нь илүү өгөөжтэй. Түүнээс гадна энд засгийн газрын туслалцаа чухал бөгөөд байгалийн баялаг ашиглах төслүүдийг засгийн газартай хамтарч хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Солонгос-Монголын эдийн засгийн харилцааны тухай ярихдаа тухайн асуудлыг Зүүн Хойд Азийн эдийн засгийн хөгжил, улс төрийн намжмал байдлын хүрээнд авч ярих нь зүйтэй. Ядруу эдийн засгаа аврах, эдийн засгийн шинэчлэлтээ тууштай явуулах, дэд бүтцээ хөгжүүлэн улмаар түмэн голын бүс нутгийн хөгжлийн төсөлд нэгдэх нь Монгол улсад тустай болох юм.

Монгол-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа. Зүүн Хойд Азийн орнуудаас Монгол улсын эдийн засаг, түүний хөгжилд сүүлийн арваад жилд эрчимтэй нөлөө үзүүлж байгаа орон бол БНХАУ юм. Монгол, Хятадын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. БНХАУ 1978 оноос эдийн засгийн шинэчлэл хийж, гадаадад нээлттэй бодлого явуулах болсон. Түүнчлэн Монгол улс 90-ээд оноос зах зээлийн системд шилжиж бие даасан гадаад бодлого явуулах болсон нь хоёр орны эдийн засгийн харилцааг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлжээ. Сүүлийн арван жилд Монгол улс, БНХАУ-ын худалдаа эдийн засгийн харилцаа эрчимтэй хөгжиж ирлээ. 1990 онд нийт бараа гүйлгээ 33,6 сая ам доллар байсан бол 1998 онд 143,3 сая ам долларт хүрч, 4.2 дахин өссөн байна.

Ийнхүү импорт 54,9 сая ам доллар, экспорт 88,4 сая ам долларт хүрчээ. Монгол улсын нийт

экспортын барааны 27,9 хувь, импортын барааны 11,6 хувь нь БНХАУ-д ногдох болов. Монгол улс түүхий эд, зэсийн баяжмал, арьс шир, ноос ноолуур, ангийн үс, гуалин банз, төмөр, цемент зэргийг Хятад руу гаргаж, Хятадаас хөнгөн үйлдвэр, хүнсний бараа, химийн үйлдвэрийн бараа авч байна. Монгол улсын зах зээлийн барааны хомсдолыг нөхөхөд Хятад улс чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол, Хятадын худалдаа зах зээлийн шаардлагын дагуу чөлөөтэй явагдаж байна. Монгол, Хятад хоёр орон хил залгаа оршдогийн хувьд хилийн худалдаа чөлөөтэй явагдаж байна. Хоёр улсын хооронд хилийн 10 боомт ажиллаж байна. Үүнээс улирлын чанартай 9 боомт, байнгын Замын Үүд-Эрээний нэг боомт ажиллаж байна. Хилийн худалдаанд бараа солилцоо зонхилох үүрэг гүйцэтгэдэг. Хил залгаа аймаг мужууд болон хотуудын хооронд эдийн засаг худалдааны харилцаа хөгжиж байна. УБ-Бээжин, УБ-Тяньжин, Өвөрхангай-Ляонин, Төв аймаг-Улаан цав, Эрдэнэт-Бугат, Дорнод-Хөлөнбуйр, Өмнөговь-Алаша зэрэг аймаг хотуудын хооронд шууд харилцаа тогтоон хамтран ажиллаж байна. Энэ нь хоёр орны худалдааны нэг онцлог гэж хэлж болно. БНХАУ экспортын чиглэлийн үйлдвэрийг дэмжиж Оросын холбооны улс болон Монголд экспортоо нэмэгдүүлэх сонирхолтой байдаг. Орчин үеийн Монгол, Хятадын эдийн засгийн харилцаанд хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл олгох, тусламж үзүүлэх зэрэг хэлбэрийг агуулж байна.

1990 оноос хойш БНХАУ-ын хөрөнгө оруулалттай 332 аж ахуйн нэгж байгуулагдсан нь нийт гадаад хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн 31 хувь буюу оруулсан хөрөнгийн 22 хувийг эзэлж байна. Зөвхөн 1998 онд БНХАУ-ын хөрөнгө оруулалттай 105 аж ахуйн газар байгуулагдсан ба эдгээр нь гол төлөв мал аж ахуй, газар тариалан, үйлчилгээ, өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийн чиглэлд хөрөнгө оруулж байна. БНХАУ-ын засгийн газар Монгол улсад 1991 онд 50 сая, 1992 онд 30 сая, 1994 онд 50 сая юаний хүүгүй зээл олгоод байна. БНХАУ-ын дарга Зян Зэ Мэний айлчлалын үеэр Монголд орон сууц барих зориулалтаар 30 сая юаний буцалтгүй тусламж олгосон. БНХАУ, Монгол улсын эдийн засгийн хүнд нөхцөл болон байгалийн гай гамшгийг гэтлэн давахад хөрөнгийн болон бэлэн мөнгөний туслалцаа үзүүлж байна. 1993 оноос хойш 30 сая ам долларын тусламж үзүүлээд байна.

Монгол улс ч БНХАУ-д учирсан газар хөдлөлт, үерийн гарз хохиролыг арилгахад зориулж 10 сая төгрөгийн ноосон эдлэл, хүүхдийн хувцас бэлэг болгон өгчээ. Монгол улс, БНХАУ хоёулаа төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд өөр өөрсдийн сонгосон зам, арга барилаар шилжиж байгаа билээ. Монгол улс БНХАУ хоёр Ази Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа, хөгжилд чиглэсэн санаачлага, хүчин чармайлтыг харилцан дэмжиж хамтран ажиллах байр суурь, хүссэн зорилго нэгтэй байгаа юм.

Япон-Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа. Япон, Монголын эдийн засгийн хороо, Монгол, Японы эдийн засгийн комисс нь засгийн газрын бус байгууллага хэлбэртэйгээр 1972 онд байгуулагдаж, 7 удаа хамтарсан хуралдаан хийгээд байна. 1957 оноос Японы хувийн пүүсүүд манай улстай худалдаа хийж эхэлсэн. 1990 онд худалдааны хэлэлцээр байгуулсан. Япон 1974 оноос манай зарим бараанд гаалийн хөнгөлөлт үзүүлж эхэлсэн. 1990 оноос хойш Монголтой хийх худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжиж Японы олон улсын худалдаа, үйлдвэрийн яамны даатгалд (100 сая ам. доллар хүртэл) өөрийн пүүсүүдээ хамруулах болсон. Иточү, Сүмитомо, Нишшо-Ивай, Марубени, Комацү, Тоёота, Мицубиши, Ничимэн зэрэг томоохон компаниуд Монголд төлөөлөгчийн газар, засвар үйлчилгээний цэгээ нээн ажиллуулж байгаа бөгөөд Японы цахилгаан бараа, автомашин, тоног төхөөрөмжийг Монголд борлуулах эрхийг манай компаниуд эзэмших болсон. 1999 оны гадаад худалдааны гүйцэтгэлээр Япон улс манай импортын 3 дахь, экспортын 5 дахь түнш орон болж байна.

Хоёр орны худалдааны эргэлт
(сая ам, доллар)

Хүснэгт №4

Он	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Экспорт	18.8	17.0	44.9	95.3	35.0	37.6	12.2	10.9
Импорт	40.0	20.8	16.7	45.3	77.8	34.7	55.2	53.1
Нийт эргэлт	58.8	37.8	61.6	140.6	112.8	72.3	67.4	64.0

Манай улс Япон улсад зэс, молибдений баяжмал, ноолуур, сүлжмэл эдлэл, адууны мах зэргийг голлон экспортолж, алт цэвэршүүлж, үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа импортолж байна.

Зээл тусламж. Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны тухай ("Говь" комбинатыг барих тухай) хэлэлцээрийг 1977 онд байгуулж, түүний хүрээнд 5 тэрбум иений (17 сая ам. доллар) буцалтгүй тусламж олгосноор Японы хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-д Монгол хамрагдах болсон. Японы ХАЁТ-ын хамтын ажиллагаа 1990-ээд оноос идэвхжиж, Япон улс Монголд олгож буй гадаадын зээл тусламжийн гуравны нэг буюу жилд дунджаар 45-50 сая ам. долларын хөнгөлөлттэй зээл, 30-35 сая ам. долларын буцалтгүй тусламж, 10 гаруй сая ам. долларын техникийн хамтын ажиллагааны тусламж олгож байна.

Японы засгийн газраас Монголд олгосон зээл тусламж
(100 сая иенээр)

Хүснэгт №5

Он	Буцалтгүй тусламж	Хөнгөлөлттэй зээл	Техникийн хамтын ажиллагаа	Үнийн дүн
1977	50.00	0	0	50.00
1978-1990	6.04	0	4.66	10.70
1991	33.08	48.36	4.02	85.46
1992	39.08	24.59	6.81	70.48
1993	45.35	33.21	18.10	96.66
1994	59.05	47.53	22.72	129.30
1995	58.25	44.93	23.37	126.55
1996	48.03	58.27	18.13	124.43
1997	50.46	42.98	19.33	112.77
1998	52.75	0	24.65	77.40
1999	53.56	0	24.43	77.9
Нийт	456.65	299.87	166.22	961.74

1997 оны 3 дугаар сард болсон "Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалт"-ын үеэр хоёр талын харилцан тохиролцооны дагуу үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулсан эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэх (эрчим хүч, тээвэр, холбоо), зах зээлийн эдийн засагт шилжихэд чиглэсэн оюуны тусламж, хүн сургалт, газар тариалан,

мал аж ахуйг хөгжүүлэх, амьжиргааны үндсэн эрэлт хэрэгцээ (боловсрол, эрүүл мэнд, усан хангамж) гэсэн 4 үндсэн чиглэлээр Японы ХАЕТ-ыг авч ашиглаж байна. Японы зээл тусламжаар "Говь" комбинат, Хархорины үр тарианы агуулах, Холбооны газрын станц, Замын-Үүдийн бараа сэлгэн ачих байгууламж, Ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийг барьж байгуулах, Дарханы махкомбинат, Улаанбаатарын сүүний үйлдвэр, Улаанбаатарын IV ДЦС, Шивээ-Овоо, Багануурын нүүрсний уурхай, сумдын дизель станцыг шинэчлэх, Налайхын асфальтан чулуун зам тавих, хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, төмөр замын тээх нэвтрүүлэх чадварыг сайжруулах, хотын нийтийн тээврийг сайжруулах, нэгдсэн II эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг нийгэм эдийн засгийн салбарын олон төслүүд хэрэгжсэн юм. Монгол улсын шилжилтийн эдийн засгийн хүндрэлтэй байдлыг харгалзан үзэж, төлбөрийн балансыг сайжруулах төслийн бүс буцалтгүй тусламжийг 7 удаа олгож нийт 12 тэрбум 400 сая иенийн хөрөнгөөр бараа нийлүүлэлт хийсэн байна. Техникийн хамтын ажиллагааны хүрээнд нийт 728 хүн Японд сурч, 291 мэргэжилтэн, 86 залуу сайн дурынхан Монголд ажиллаж, хөгжлийн 25 судалгаа хийж, төсөл хэлбэрийн техникийн хамтын ажиллагаа гурвыг хэрэгжүүлжээ. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын төлөөлөгчийн газар 1997 оноос Монголд үйл ажиллагаагаа явуулж байна. 1993 онд баруун гурван аймагт учирсан байгалийн гамшиг болон 1996 оны хавар гарсан ой, хээрийн түймрийн хохирлыг давахад зориулан Японы засгийн газар тус тус 100000 ам. долларын хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлсэн. Мөн 1999-2000 оны зудын бэрхшээлийг гэтлэн давахад зориулж 50 мянган ам. долларын тусламж, 2000-2001 оны ган гачиг, зудын гамшгийг хохирол багатай давахад зориулж 1 тэрбум 43 сая 200 мянган иенийн буцалтгүй тусламжийг тус тус олгов. 2000 оны 10 дугаар сард Монгол Японы эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатарт хоёр дахь удаагаа зохион байгуулж, урьд тохиролцсон ХАЕТ-ын тэргүүлэх чиглэлийг тодотгож, мэдээллийн технологи, харилцаа холбооны болоод халдварт өвчний эсрэг авах арга хэмжээний хүрээнд хамтран ажиллахаар тохиролцов.

Хөрөнгө оруулалт. 2000 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар Японы шууд хөрөнгө оруулалтаар "Мобиком" корпораци, "Ханамаса" зоогийн газар, "Цэцэг" зочид буудал зэрэг Японы талаас 48.5 сая ам. долларын хөрөнгө оруулалттай 102 аж ахуйн нэгж бүртгэгдэн үйл ажиллагаагаа явуулж байна. Японы ЭКСИМ банкны арилжааны зээлээр Иточү пүүс, Монгол Улсын Засгийн газрын хэлэлцээрийн дагуу Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийг барьж байгуулав. Мөн бизнесийн шугамаар "Эрдэнэт" үйлдвэр, "Эрэл", "Монгол газар" пүүсүүдэд үйлдвэрлэлийн шинэчлэл алт олзворлоход зориулж олгосон Иточү пүүсийн зээл, "Буян" компанийн ноолуурын үйлдвэрт олгосон Марубени пүүсийн зээл зэргийг ашиглав. ЖАЙКА-ийн хөнгөлөлттэй зээлийг Японы Вакамару пүүст адууны мах боловсруулж Японд нийлүүлэх зориулалтаар олгосон нь хөрөнгө оруулалтыг Японы Засгийн газраас дэмжсэн нь ач холбогдолтой болов. Японы эдийн засгийн байгууллагуудын холбоо КЕИДАНРЭН-ий хүндэт Ерөнхийлөгч Г.Хирайва тэргүүтэй төлөөлөгчид 1994 онд Монголд айлчлав. Японы хөрөнгө оруулагчид худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, ресторан, зочид буудал хөнгөн ба хүнсний үйлдвэрийн чиглэлээр зонхилон хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулалтын чиглэлээр зохиогдож буй уулзалт семинарт идэвхитэй оролцож байна. Хоёр засгийн газрын хооронд хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих харилцан хамгаалах хэлэлцээрийг 2001 оны 2 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр байгуулав.

Монгол улс дотооддоо эдийн засгийн интеграцийн бүтцийг бий болгох нь. Монгол улс өөрөө цаашид хөгжихийн тулд интеграцид нэгдэх нь чухал гэдгийг ухамсарлаж анхны алхмуудаа хийж байна. Манай улсын хувьд АНД-н интеграцийн процесст нэгдэх асуудал нь өнөө маргаашийн зорилт биш алс хэтийн төлөвлөлт байх ёстой.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө улс орны нийгмийн байдал, дотооддоо авч хэрэгжүүлж байгаа шинэчлэлийн үйл явцтай уялдуулж тодорхой үе шаттайгаар авч үзэх нь зүйтэй юм.

Зах зээлийн эдийн засаг нь интеграцийн процессгүйгээр хэрэгжихгүй. Интеграцид оролцох нь зөвхөн хамтран ажиллах хэлбэр биш үнэ, мөнгөний бодлого, татвар, төсөв, худалдааг дэмжсэн бодлогыг тухайн орнуудтай ойртуулж хуульчилж өгөх явдал юм. Дэлхий дахин улам интеграцид орж глобалчлагдаж байгаа өнөө үед Монгол улс дэлхийн бусад оронтой ямар харилцан хамааралтай байж ямар замаар улсаа хөгжүүлэх вэ? гэдэг асуудал юу юунаас илүү чухал болж байна. Үүний тулд өнөөгийн гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны хүчин зүйл, тухайлбал:

- Бүс нутгийн интеграцид нэгдэх шаардлага, үндэслэл
- Өөрийн орны нөөц бололцоо, боломж
- Чиглэл зорилго, хэрэгжүүлэх үе шат зэргийг тодорхойлж бүс нутгийн орнуудтай хоёр талын хамтын ажиллагааг бүхий л хэлбэрээр хөгжүүлж худалдааг өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтарсан объект байгуулах гэх мэтээр ажиллах нь зүйтэй.

Монгол улсын хувьд харьцангуй буурай хөгжилтэй, үндэсний үйлдвэрлэл болон эдийн засгийн салбарын бүтэц хөгжөөгүй учир санхүү эдийн засаг, технологийн асуудлуудыг бие даан шийдвэрлэх боломжгүй юм. Иймд эдийн засгаа босгоход дэлхийн нийтийн туршлагад тулгуурлан интеграцийн янз бүрийн хэлбэрийг ашиглах нь зохистой.

Монгол улсын хувьд интеграцийн дараах хэлбэр илүү үр өгөөжтэй байж болох юм.

- Таваарын солилцоо
- Шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн капиталын зах зээлтэй харилцах
- Үйлчилгээ үзүүлэх
- Хөгжилтэй орнуудад ажиллах хүч гаргах

Монгол Улсын хувьд Зүүн Хойд Азийн орнуудтай интеграцид орж улс орныхоо хөгжлийг түргэтгэхэд нарийн бодож боловсруулсан төлөвлөгөө, интеграцийн загвар шаардлагатай. Улс орон даяар хэрэгжүүлж байгаа эдийн засгийн шинэ загвар нь юуны түрүүнд эдийн засгийн интеграцийн олон хэлбэр дээр үндэслэгдсэн байх нь чухал. Үүнд субъектүүдийн хоорондын түншлэлийн хэлбэрийг сонгож, зарчмаа нарийн бодож боловсруулахаас гадна тэдгээрийн эдийн засгийн хувьд бие биэндээ хэрэг болох гол зарчмыг тооцох нь чухал.

Улс оронд интеграцийн процессыг амжилттай хэрэгжүүлэхэд улс төрийн хувьд нэгдмэл байх нь чухал. Монгол улсад төрийн дээд байгууллага болох Монгол улсын их хурал, ерөнхийлөгч түүний тамгын газар, төрийн хууль ёсыг тогтоон журамлах, засгийн газар нь гүйцэтгэн зохицуулах үүрэг эрэмбийг багтаасан төр засгийн үйл ажиллагааны тогтолцоог бүрэлдүүлж байгаа нь нийгмийн амьдрал, эдийн засгийн системийг шинэчлэх гол утгвар нөхцөл болно. Ази - Номхон далайн бүс нутгийн интеграцид Монгол улсыг түлхүү оруулж нэгэнт эхэлсэн зах зээлийн харилцааг богино хугацаанд төлөвшүүлэхэд төр засгийн үүрэг роль урьд урьдаас илүү онцгой болж байна. Улс орны эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөлд гадаадын хүчин зүйлийн ролийг эрс нэмэгдүүлэхэд төрийн зүгээс зохицуулах механизмыг чадмаг ашиглах нь чухал. Гэхдээ зах зээлийн эдийн засгийг монгол орны хөрсөнд суурилуулах номлол, үе шат арга механизм нь хуучин социалист гэгдэж байсан Зүүн Европын болон Азийн зарим орнуудынхаас эрс ялгаатай болохыг харгалзан үзэх ёстой.

Төрийн зохицуулах үйл ажиллагаа нь юуны өмнө дараах асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэх ёстой.

Төрийн хүчийг хөгжлийн хүчин зүйл болгон ашиглах нь. Зах зээл нь нийгмийн бүхий л үйл явцыг өөрөө зохицуулж зах зээлийн харилцаа өөрөө төлөвших ёстой гэдэг ойлголт буруу юм. Харин ч зах зээлийн эдийн засагтай улс оронд нийгэм эдийн засгийн бүхий л амьдралыг төрөөс хуульчлан зохицуулж байдаг жамтай билээ. Улс төрийн тогтвортой байдлыг хангаж,

нийгмийн бүх хүч нөөцийг зангидан төвлөрүүлж, хөгжилд чиглүүлбэл хөгжил өөрөө урсгал шинжээ орхиж чиглэсэн зорилготой болж чадна. Ийнхүү эдийн засаг үзэл суртлын хүчтэй бодлогоор хөгжлийн хурдасгагчийн үүргийг гүйцэтгэх төрийн капитализм өнөөдөр ч хэрэгтэй байна. Зах зээлийн нэгэн онцлог нь үйлдвэр, аж ахуйн газарт бүрэн эрх мэдэл олгох, удирдлага нь өдөр тутмын үйл ажиллагаагаа бие даан шийдэж явуулах, чөлөөт шударга өрсөлдөөнд оролцох, ингэснээр эдийн засгийг үр ашигтай болгож, нийгмийн баялгийг үр өгөөжтэй зарцуулах, хуваарьлах боломжийг бүрдүүлэхэд оршдог.

Манай улсын үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөдөлмөр зарцуулалт ихтэй үйлдвэрлэлийн уламжлалт аргыг өөрчилж шинжлэх ухаан техникийн дэвшлийн тэргүүлэх чиглэлүүдэд илүү анхаарч хүн рүүгээ хөрөнгө оруулалт хийх нь хөгжиж, дэвшихийн эх булаг болох ёстой. Үүнд төрийн хүчийг хөгжлийн хүчин зүйл болгон ашиглах нь чухал юм. Эдийн засгийн ийм тогтолцоог хангах төр, үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хоорондын эдийн засгийн харилцааг зохицуулах хуулиудыг төрөөс тогтоож нийгмийн амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх нь төрийн зохицуулалтын үндэс мөн.

Монгол улсын засгийн газар юуны өмнө улс орны нийгэм эдийн засгийн уналтыг зогсоох, цаашдын өсөлтийг хангахад чиглэсэн төлөвлөгөө, хөтөлбөр хэтийн хөгжлийн стратеги, үзэл баримтлал бүс нутгийн интеграцид тохирсон эдийн засгийн загвар боловсруулан ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг шинэчлэн боловсруулж мөрдөх, үүндээ гадны хөрөнгө оруулалтыг татахуйц сонирхлын тогтолцоо бий болгох;
- Гадаадын байгууллага, иргэдэд газар түрээслүүлэх хууль зүйн баталгааг бий болгох;
- Үндэсний үйлдвэрлэлийг сэргээх, үүний тулд юуны өмнө засгийн газрын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын банкныг байгуулан ажиллуулж улсын болоод хувийн үйлдвэрийг дэмжих, хуучин үйлдвэрийг шинэчлэх, шинээр үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд зориулж хангалттай зээл олгох;
- Экспортыг дэмжсэн татварын бодлогыг хэрэгжүүлэх;
- Гадаад валютын нөөцийг бүрдүүлэхийн тулд экспортын квотыг ашиглах, аж ахуйн нэгж байгууллагын бие даасан хөрөнгө оруулалтыг дэмжих эдгээр болно.

Зах зээлийн хуулийн дагуу улс орны эдийн засгийг санхүүгийн аргаар удирдан зохицуулах системд шилжих нь зайлшгүй бөгөөд уг үйл явцын онцлог түүнчлэн зах зээлийн шилжилтийн үеийн эдийн засагт бий болох нэгдсэн бүтэц зэргийг судлах шаардлага зайлшгүй гарч байна. Зах зээлийн үед эдийн засгийг санхүүгийн аргаар удирдахад бүтэц зохион байгуулалтын олон хэлбэр шаардлагатай.

Санхүүгийн капиталыг бий болгох нь. Санхүүгийн капитал нь эдийн засгийн үйл явцыг зохицуулах гол хүчин зүйл мөн. Улс орны эдийн засагт зах зээл бүрэлдэж бий болох явцад санхүүгийн капитал нь аажмаар интеграцийн процессыг зохицуулах үндсэн механизм болох ёстой. Санхүүгийн капитал гэдэгт аж үйлдвэрийн хувь нийлүүлэгчдийн капитал нь банкны капиталтай нэгдэж байгаа тэр хэсгийг хэлж байгаа юм. Өнөөгийн нөхцөлд санхүүгийн капиталыг бий болгох гол хэлбэр нь санхүү-аж үйлдвэрийн бүлэглэл байгуулах явдал юм. Дэлхий дахины хөгжлийн явцаас харахад капиталын бөөгнөрөл, төвлөрөл, санхүү, аж үйлдвэрийн корпорациудын харилцан ойртолт, тэдгээр нь улсын хил хязгаараас гарах, дэлхийн болон тухайн улс орны эдийн засагт тэргүүлэх үүрэг гүйцэтгэх санхүү, аж үйлдвэрийн бүлэглэл үүсэх нь зайлшгүй болох нь илт байна. Ерөнхий зорилтуудыг шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан санхүүгийн төрөлжсөн байгууллага бүхий капиталаараа харилцан холбоотой үйлдвэрийн газруудын бүлэглэлийг санхүү-аж үйлдвэрийн бүлэг гэдэг. Одоо үед санхүү-аж үйлдвэрийн бүлгүүд дэлхийн хөгжилтэй ихэнх орны эдийн засгийн үйл ажиллагааны бүтэц,

онцлогийг олон талаар тодорхойлж байна. Санхүү, банкны болон аж үйлдвэрийн капиталын гаргалт бол олон улсын эдийн засгийн байгууллагууд, тухайлбал, үндэстэн дундын банк үүсэн бий болох үндэс мөн.

Манай улсын хувьд эдийн засгийг санхүүгийн аргаар удирдах, чөлөөт зах зээлийг бий болгох эхний оролдлогууд хийгдсэн нь үндсэндээ хүн бүрийг хувийн өмчтэй болгохыг баримтласан боловч томоохон үйлдвэрүүдийг хижиглэн хуваасан нь буруу юм. Энэ нь төр засгийн газраас эдийн засгийг удирдах зарим үүрэг функцээс татгалзсан хэрэг байлаа. Үйлдвэрүүдийн акцийг хувьцаа хэмээгдэх тасалбараар хувь хүмүүс болон ажилчдад хувиарлан өгсөнөөр хүн болгоныг ажилладаг ажилладаггүй машин техник, байшин сав, эд хөрөнгийн эзэн болгов. Энэ үед үйлдвэрүүд нь технологийн шинэчлэл хийх, өргөтгөл хийх, түүхий эдээ худалдан авах эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэх боломжгүй болж зогсоход хүрсэн юм. Ер нь нь өөрийн хөрөнгө мөнгийг зарцуулаагүй хувьцаа эзэмшигчид үйлдвэрийн менежментийн болон цаашдын хөгжлийн асуудалд хариуцлага хүлээж санаа тавьдаггүй идэвхгүй хэсэг байдаг юм. Ийнхүү манайд анхнаасаа зах зээлийн үед санхүүгийн капиталын гүйцэтгэх үүрэг ролийг дутуу үнэлсэн нь харагдаж байна. Юуны өмнө санхүүгийн капитал нь хөрөнгө мөнгийг нэгтгэн интеграцийн хэлбэрт оруулж байдаг. Манай улсын эдийн засагт томоохон байр эзлэх Эрдэнэт, Говь, Ээрмэл, Арьс шир, Шеврод, Булгиар, Гутал, Нэхий эдлэл, Төмөрлөг, Мах, Сүү, Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрүүд болон эрчим хүч, уул уурхай, нефть хангамжийн компаниудын хувьчлалыг гадаад дотоодын банк санхүүгийн боломжинд тулгуурлан Улс орны үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлын үүднээс сайтар бодолцон боловсруулсан тусгай хөтөлбөрийн дагуу явуулах нь зүйтэй байсан юм. Санхүүгийн капитал нь эдийн засгийн үндсэн ухагдахуун болохын хувьд хувь нийлүүлсэн капитал дээр тулгуурлаж байдаг. Монгол улс дотооддоо капиталыг нэгтгэх зохион байгуулалтын олон хэлбэрүүдийг оновчтой ашиглан үйлдвэр, банк хоёр хамтран ажиллах механизмыг бий болгож санхүү аж үйлдвэрийн бүлэглэлийг үүсгэх нь чухал. Монгол Улсад үйлдвэр санхүүгийн бүлэглэл байгуулахад зохион байгуулалтын дараах ажлуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төр засгаас зах зээлийн үйл явцыг удирдан зохицуулах ажлыг хүчтэй болгох;
- Аж ахуйн буюу захиргааны нэгжүүдийн уялдаа холбоог сайтар зохицуулах механизмыг бий болгож, журмыг хуульчилж өгөх;
- Хөрөнгө, мөнгө, төрөл бүрийн томоохон үйлдвэрийг аль болох нэгдмэл томоохон хүч болгохыг зорих;
- Томоохон үйлдвэрүүдийн хувьчлалд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, таатай нөхцөл олгох;
- Үйлдвэрийн хөгжлийг дэмжих засгийн газрын буюу гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулах, төр засгаас дэмжлэг үзүүлэх;
- Банкуудыг нэгтгэж үйлдвэрийн акцуудыг худалдах ингэснээр үйлдвэр санхүүгийн программыг хангаж мөнгөний эргэлтийг хянах боломжтой болгох эдгээр болно.

Мөн орчин үед аж ахуйн амьдралыг интеграцчилах гол хэлбэрийн дэлхий нийтийн ерөнхий хандлага нь хөгжилтэй орнуудаас хөгжиж байгаа орнуудад капитал оруулах явдал бөгөөд тэр нь хөгжилд хүчтэй түлхэц өгч байна. Эл зорилгоор манай улсад түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, зарим нарийн эд ангийг үйлдвэрлэх, гадаадын үйлдвэрүүдийг ч байгуулах шаардлагатай. Өөрийн нийгэм эдийн засгийн мөн чанарын хувьд иймэрхүү шилжин байршил нь улс төр, эдийн засаг, хүрээлэн байгаа орчинтой нөхцөлдсөн үндэстэн, улс дамжсан корпорацийн бодлогын орчин үеийн чиглэл юм.

Худалдааны бодлогыг сайжруулах. Эдийн засгийн интеграцийн үйл явцын өрнөл нь сүүлийн арван жилд олон улсын худалдааны хүрээнд хамгийн илүү тогтвортой явагдах боллоо. Гэхдээ фермер хоорондын хүрээнд технологийн (үйлдвэрлэлийн) тогтвортой үйлчилгээ, удаан хугацааны хоршилт, хамтран гүйцэтгэх ажлын үндсэн дээр эрчимжсэний үрээр бараа

үйлчилгээний өсөлт нэмэгдэж энгийн худалдаа наймааны хэмжээ харьцангуй буурах болсон юм. Дэлхийн таваарын зах зээл, үйлчилгээний зах зээлтэй нягт харилцан уялдах боллоо. Монгол улс хэдийгээр дэлхийн худалдааны байгууллагын гишүүн олон оронтой гааль худалдааны таатай нөхцөл, давхар татварын гэрээ байгуулсан, уламжлалт зах зээлтэй боловч сүүлийн жилүүдэд худалдааны баланс алдагдаж экспорт улам хумигдах боллоо. Энэ нь Монгол улс Ази Номхон Далайн интеграцийн салшгүй нэг хэсэг болохын хувьд худалдааны бодлогыг дотооддоо цэгцэлж бүс нутгийн интеграцтай уялдуулах шаардлагатайг харуулж байна.

Чөлөөт бүс. Эдийн засгийн чөлөөт бүс нь тухайн орны эдийн засгийн хөгжлийг хурдасгах зорилгоор сонгон авсан газар нутагтаа гааль, худалдаа, татварын хөнгөлттэй нөхцлийг олгож ажиллуулдаг тусгай бүс бөгөөд эдийн засгийн туршилтын талбар болж байна. Ийм бүс өнгөрсөн зууны эцсээр үүсч хөгжсөн түүхтэй. Онцлог нутгууддаа хөрөнгө оруулалт, дэд бүтцийг төвлөрүүлэх үүднээс гол төлөв хөгжиж буй орнууд энэ аргыг хэрэглэдэг. Сүүлийн 10-аад жилд эдийн засаг нь эрчимтэй хөгжиж байгаа. Зүүн Өмнөд Азид эдийн засгийн чөлөөт бүсийн эд өрнөлт явагджээ. Одоогоор нэлээд дэлгэрэнгүй байгаа чөлөөт бүсийн хэлбэрүүдийг дараах төрлүүдээр ангилж болно.

- Чөлөөт боомт – худалдааны чөлөөт бүс (Гонконг, Сингапур)
- Эдийн засгийн чөлөөт бүс (Тяньцзинь, Хятад)
- Экспортын үйл явцыг эрхэлдэг бүс (Солонгос, Тайвань, АСЕАН)
- Худалдааны чөлөөт бүс (Панам, Абу-Даби)
- Импортын үйл явцыг эрхэлдэг бүс (АНУ)
- Экспорт-импорт үйл явцыг эрхэлдэг бүс (Хятад, АСЕАН)

Зүүн хойт азийн чөлөөт бүс. 1990-ээд оноос ОХУ, Хятад, БНАСАУ-д эдийн засгийн чөлөөт бүс хэд хэдийг зарлан нээж ажиллуулсан боловч төдийлэн амжилттай хөгжихгүй байна. Үүнд:

- Хятад: Манжоули, Суйфэнхэ, Хуньчин, Уоука
- БНАСАУ: Ражин-Сонбони
- ОХУ: Владивосток-Находка, Чита, Сахалин

Эдгээр бүс нутагт эдийн засгийн чөлөөт бүс эрчимтэй хөгжихгүй байгаа нь дараах шалтгаантай холбоотой гэж үзэж болох юм. Тухайлбал:

- Хятад улсад дэд бүтэц сайн хөгжөөгүй;
- БНАСАУ-д хөрөнгө мөнгө дутагдалтай;
- ОХУ-д улс төр, эдийн засгийн байдал тогтворгүй байгаа зэрэг болно.

Тухайн бүс нутгийн хувьд улс орон бүрт хөгжлийн болон чөлөөт бүсийн төслийг удирдан зохион явуулах субъектууд нь өөр өөр байгаагаас шалтгаалан адил тэгш, хамтын ажиллагааны харилцааг тогтоож чадахгүй байна. Тухайлбал:

Японд	- Орон нутгийн засаг захиргаа
Солонгост	- Төв Засгийн газар
Хятад	- Орон нутгийн засаг захиргаа
ОХУ-д	- Орон нутгийн засаг захиргаа
Хойт Солонгост	- Төв Засгийн газар
Монголд	- Төв Засгийн газар нь тус тус хөгжлийн болон чөлөөт бүсийн

төслийг хариуцаж байна. Мөн бүс нутагт хөгжлийг түргэтгэхэд бэрхшээл учруулж байгаа дээрх нөхцлүүдээс гадна хил хязгаар, газар нутгийн болон дипломат харилцаа тогтоогдоогүй гэх зэрэг улс төрийн шалтгаан ч нөлөөлж байна. Эндээс үзэхэд Өмнөд Солонгос, Хойт Солонгос, Монгол хоорондын хөгжлийн төлөвлөгөө нь төр засгийн төсөл байх бөгөөд Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулагдаж бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх

боломжтой юм. Ер нь дэлхийн практикт эдийн засаг улс төрийн өргөн цар хүрээтэй бүрэн гүйцэд харилцан үйлдлийн зайлшгүй нөхцөл нь интеграцид оролцож буй талууд буюу улсуудад эдийн засгийн ойролцоо систем (аж ахуйн загвар) бий болгох нь чухал байдаг. Иймээс Зүүн хойд Азийн бүс нутгийн интеграцид шинэ тутам орж буй орнууд дотооддоо зах зээлийн механизмыг жинхэнэ ёсоор зүгшрүүлэх, зах зээлийн зүгшүрсэн механизмтай болсон. АНУ, Япон, БНСУ зэрэг оронтой тэргүүлэх чиглэлээр эрчимтэй хамтын ажиллагаа явуулах нь зах зээлд амжилттай оролцох үйл явцыг хурдасгахад сайн нөлөө үзүүлнэ. Монгол улс дотооддоо чөлөөт бүс байгуулах бэлтгэлийг сайтар хангах, чөлөөт бүсийн тухай хуулийг баталж өгөх нь зүйтэй юм. Мөн манай улсын онцлогт тохирсон ямар хэлбэрийн бүс байх вэ гэдгийг ч бодолцох нь чухал. Зүүн хойд Азийн интеграцийн хүрээнд Монголын Дорнод хэсэгт ийм бүс байх нь тохиромжтой боловч энэ нутгийн байгалийн нөөц, малын тоо толгой, бэлчээр, хүний суурьшил, зэргийг сайтар тодорхойлж дэд бүтцийг хэрхэн хөгжүүлэхээ төлөвлөх хэрэгтэй.

Энд Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь аймгуудийг нэгтгэсэн Дорнод Монгол-Шинэ хөгжлийн бүс байгуулж Дорнодод төвийг нь байгуулж болох юм. Гэхдээ энэ бүс нь цоо шинэ загварын байхаас гадна Азийн эргэн тойронд байгуулагдсан чөлөөт бүсүүдтэй өрсөлдөхийн тулд тэдгээртэй ойролцоо буюу ямар нэг талаар илүү хөнгөлттэй хууль тогтоомж, санхүү хөрөнгө оруулалтын нөхцлийг бий болгох хэрэгтэй. Ялангуяа газар өмчлөл ба түрээслэл, албан татвар, гааль, иммиграци, мөнгө солилт, орлогоо гадагшаа чөлөөтэй гуйвуулах боломж, ажиллах хүчний хөдөлгөөн зэргийн талаархи дүрэм журам нэн чухал. Хөрөнгө оруулагчид дэлхий даяар шилж сонгох өргөн боломжтой байдаг. Ийм тохиромжтой нөхцлийг бий болгож чадахгүй юм бол чөлөөт бүсийг хөгжүүлэх зохих хөрөнгө оруулалтыг татахад бэрхшээлтэй байх болно.

Монголд чөлөөт бүсийг хөгжүүлэхэд анхаарах зүйлүүд гэвэл:

- Тухайн орон тусгайлан заасан газар нутагтаа улсаас зориуд хөрөнгө гаргаж дэд бүтцийг сайтар хөгжүүлсэн байх;
- Нөөц бололцоог сайтар судлан илрүүлсэн байх;
- Доогуур тогтоосон гаалийн татвар хураамжтай байх;
- Тухайн бүс нутагт үйлчлэх хууль зүйн тусгай дэг журмыг засгийн газраас тогтоосон байх;
- Ашиг орлого, үл хөдлөх хөрөнгөөс хураах хөнгөлттэй татвартай байх;
- Хөлсний хөдөлмөр чөлөөтэй эрхлэх хууль гаргах;
- Гадаадын хөрөнгө оруулах тусгай нөхцөлтэй байх;
- Орон нутгийн удирдлагын бие даасан эрхийг илүү чөлөөтэй байлгах шаардлагатай.

Дэд бүтцийн хувьд. Монгол улс Зүүн Хойт Ази, Түмэн Голын гурвалжинд өөрийн улсын ашиг сонирхолыг бий болгож, харилцан ашигтай хамтран хөгжих өргөн боломж бий. Түмэн гол Хятадын эх газраас Япон тэнгист нэвтрэх цорын ганц усан зам юм. Тэр нь Япон тэнгис, Оросын Алс Дорнодын эрэг орчмын нутаг болон Солонгосын хойгийн зүүн эрэгт ойрхон бөгөөд Монгол улсын далайд гарах хамгийн ойр гарц юм. Түмэн голын боомтоос Канад, Америк хүртэл далайн тээврийн зам Тяньжин, Гуанжоу, Шанхайгаас илүү дөт юм. Нөгөөтэйгүүр Хятадын зүүн хойд нутаг, Монголоор дамжин Евро-Азийн эх газрын гүүр барьж байгуулах ажлыг Япон, Солонгос ихэд сонирхож байгааг Монгол улс бодолцох нь зүйтэй. Иймд Дорнодын Тамсаг булгийн төмөр замыг яаралтай сэргээн өргөтгөн засварлаж Хятадын төмөр замтай холбох хэрэгтэй байгаа юм. Энэ нь Монгол Улсад ямар ач холбогдолтой вэ гэвэл:

Нэгд: Монгол улс хамгийн дөт замаар далайд гарцтай болох юм.

Хоёрт: Япон, Солонгосоос их хэмжээний барааг Монголын нутгаар дамжуулан Европт гаргах боломжтой. Мөн ирээдүйд өндөр хурдтай зам бий болговол агаараар тээвэрлэсэнээс харьцуулашгүй хурдан, хямд байх болно.

Гуравт: Монгол улс энэ эх газрын гүүрийг ашиглан Хятадын зүүн хойд мужаар дамжин Хойд

Солонгосын Rajin-ний боомтыг ашиглах гэрээ байгуулж болно.

Монгол улс ЗХА-ийн интеграцид нэгдэж орох загварын товч тойм. Монгол улсад Зүүн Хойд Азийн интеграцид нэгдэн орох тусгайлан боловсруулсан концепц шаардлагатай. Ийм концепц боловсруулахад манай улсын дорнод хэсэг Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь аймгуудыг хамтруулан засаг захиргааны болон эрх зүйн тусгай орчинг бүрдүүлж "Дорнод Монголын-Шинэ хөгжлийн бүс" байгуулах явдал юм. Энэ концепци нь тухайн бүс нутгийн байгалийн болон ашигт малтмалын арвин нөөц, газар зүйн ашигтай байрлал, харьцангуй хөгжсөн дэд бүтэц зэрэгт тулгуурлах ёстой. Дорнод Монголын-Шинэ хөгжлийн бүсийн төвийг Дорнод аймагт төвлөрүүлж засаг захиргааны биеэ даасан эрхийг нэмэгдүүлж өөрийгөө санхүүжүүлэн хөгжих нөхцлийг бүрдүүлж өгөх нь зүйтэй. Энд юуны өмнө бүс нутгийн хөгжлийн цоо шинэ концепци боловсруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэн тусгай нөхцлийг бий болгож, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийх явдал чухалаар тавигдаж байна.